


ОРЛОГО (тэрбум төгрөг)



Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэл

53.6
-3.4% ↓



Даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн

3.0
-26.1% ↓



Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн

36.7
-17.5% ↓



Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн

14.0
98.7% ↑

ИРГЭД, 2021 оны 2 дугаар сард (мянган хүн)



Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид

2 965.7
2.4% ↑



Шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд

665.5
-2.4% ↓



Шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд

50.3
-40.1% ↓



Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд

2 249.9
5.6% ↑

ЗАРЛАГА (тэрбум төгрөг)



Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний багцын зардал

125.2 2.6* ↑



Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал

118.4 2.7* ↑



Сувиллын тусламж, үйлчилгээний зардал

0.5 -30.8% ↓



Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал

6.3 64.9% ↑

* - дахин их



2/2021

Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 13



Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны эхний 2 сард 53.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (3.4%) тэрбум төгрөгөөр буурч, харин эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний зардал 125.2 тэрбум төгрөг болж, 77.1 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага*, төрлөөр, сая төгрөгөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-II	2021 I-II	$\frac{2021 \text{ I-II}}{2020 \text{ I-II}}$ %
Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого	55 532.8	53 647.0	96.6
Даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн шимтгэл	4 041.3	2 984.6	73.9
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	2 839.9	2 139.2	75.3
Малчин	879.7	666.6	75.8
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	321.6	178.8	55.6
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	44 445.7	36 660.7	82.5
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	7 045.8	14 001.7	198.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардал	48 105.6	125 197.6	260.3
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	43 535.7	118 400.1	272.0
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	773.0	535.0	69.2
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	3 796.9	6 262.5	164.9

* Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого буурсан нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл 36.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 (17.5%) тэрбум төгрөгөөр буурснаас голлон шалтгаалжээ.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдагчид, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2020 II	2021 II	$\frac{2021 \text{ II}}{2020 \text{ II}}$ %
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид	2 895 942	2 965 668	102.4
Шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд	681 644	665 503	97.6
Төсөвт байгууллагын ажилтан	226 097	213 087	94.2
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	455 547	452 416	99.3
Шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд	83 997	50 287	59.9
Малчин	20 809	13 162	63.3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	55 611	33 547	60.3
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	7 496	3 521	47.0
Бусад даатгуулагч	81	57	70.4
Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд	2 130 301	2 249 878	105.6

Тайлбар: ЭМД-д даатгуулагчид давхардсан тоогоор орсон болно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Улсын хэмжээнд 2021 оны 2-р сард эрүүл мэндийн даатгалд давхардсан тоогоор 2.9 сая даатгуулагч хамрагдсаны 22.4 хувь нь шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд, 1.7 хувь нь шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд, 75.9 хувь нь шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр улсын хэмжээнд эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалт 2021 оны эхний 2 сарын байдлаар 10.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.6 (79.5%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин энэ оны 2 дугаар сард эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалт 4.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 491.3 (9.1%) сая төгрөгөөр буурсан байна.

Зүрх судасны эмийн борлуулалт 2021 оны эхний 2 сард 4.7 тэрбум төгрөг болж, нийт борлуулалтын 45.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалт, хамгийн их борлуулалттай эмийн нэр төрлөөр, сая төгрөгөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-II	2021 I-II	$\frac{2021 \text{ I-II}}{2020 \text{ I-II}}$ %
Дүн	5 724.5	10 276.3	179.5
Зүрх судасны эм	2 592.1	4 666.4	180.0
Халдварын эсрэг бэлдмэл	1 479.5	969.8	65.5
Ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм	468.2	1 667.3	356.1
Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм	511.6	881.0	172.2
Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл	256.4	803.3	313.3
Бусад эм	416.7	1 288.5	309.2

Эх үүсвэр: ЭМДЕГ-ын захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сард эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг хамгийн их борлуулалттай 5 эмийг өмнөх онтой харьцуулахад халдварын эсрэг бэлдмэлийн эм 509.7 (34.5%) сая төгрөгөөр буурч, харин сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм 369.4 (72.2%) сая төгрөг, зүрх судасны эмийн борлуулалт 2.1 (80.0%) тэрбум төгрөг, бусад төрлийн эмийн борлуулалт 871.8 (3.1 дахин) сая төгрөг, даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл 546.9 (3.1 дахин) сая төгрөг, ходоод гэдэсний замын өвчнийг эмчлэх эм 1.2 (3.6 дахин) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Ойлголт, тодорхойлолт:

Эрүүл мэндийн даатгал: Төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг хэлнэ.

Даатгуулагч: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж, эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ.

Бусад даатгуулагч: Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.9-т зааснаас бусад даатгуулагчид орно.

Шимтгэлийг улсын төсвөөс хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ асарч буй эх, эцэг, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж буй ялтан орно.

Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-т заасан тэтгэвэр авагчид, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т заасан иргэдийг хэлнэ.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн: Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 -д заасан Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 15



*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
статистикч Э.Ариунчимэг
Утас : (976-51)-263966*

